



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.02.09 № 09

Тэтгэврийн нэмэгдлийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 242 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг 80,000 төгрөгөөр нэмэгдүүлэх, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 769,000 төгрөгөөр, бүрэн бус тэтгэврийн доод хэмжээг 652,400 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

Өндөр насны “бага” тэтгэвэр авч байгаа ангилалд хамаарах иргэд ажил хөдөлмөр эрхэлж байх тухайн цаг үеийн мөнгөний ханшаар нийгмийн даатгалын шимтгэл төлснөөрөө бага тэтгэвэр авч байгаа асуудалд төрөөс тодорхой арга хэмжээг авсаар ирсэн хэдий ч өнөөдрийн өргөн хэрэглээний барааны үнийн өндөр өсөлт цалин, тэтгэвэртэй уялдахгүй байгаагаас нийгмийн дундаж давхаргыг бус ядуурлыг нэмэгдүүлэхэд хүргээд байна.

Тухайлбал, оны өмнөх тэтгэврийн нэмэгдэл болон эмч, багш нарын цалин багахан нэмэгдэх сургаар өргөн хэрэглээний барааны үнэ улам бүр нэмэгдсэн нь тэтгэврийн 80,000 төгрөгийн нэмэгдлийн үнэ цэнэ мэдрэгдэхгүйд хүргэж байгаа асуудалд танай салбарын баримтлах бодлого, авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээтэй холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1. Монгол Улсын Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Тэтгэврийн хэмжээг 80,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Монгол Улсын өнөөдрийн инфляцтай уялдаж чадаж байна уу? Тийм гэж үзсэн бол хэрхэн уялдаж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2. Засгийн газар цаашид тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбоотой баримталж байгаа бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөний талаарх мэдээлэл;

3. Тэтгэврийн доод хэмжээ манай улсын хувьд нэг сарын хугацаанд амьдралын наад захын хэрэглээг хангах боломжтой эсэх талаар тооцоо, судалгаа хийсэн эсэх, тухайн судалгааны үр дүн, тооцоолол;

4. Бүрэн тэтгэврийн доод хэмжээг 1.5 сая төгрөгт хүргэхэд шаардагдах хугацаа, эсхүл бага тэтгэвэр авагч иргэдийн нийгмийн баталгааг хангаж хүрэхүйц тэтгэврийн түвшинд хүргэх талаар тооцоо, судалгаа байгаа эсэх талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд хариуг ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.АЛТАНГЭРЭЛ

ТХС3764 9833051383 8087184

2026000025